ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

## 2023

www.1212.mn

Улаанбаатар хот
2024 он

ХЯНАСАН:
Д.Мөнхзул Чингэлтэй дүүргийн Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:
Ч.Элбэгжаргал Чингэлтэй дүүргийн Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ III БАЙР, 401 тоот
Утас:70113013
70130767
70110767
11-310767
51-261125
Цахим хуудас: www.ubstat.mn
И-мэйл: chingeltei@nso.mn

# АГУУЛГА

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ:



I. ГАЗАР ТАРИАЛАН



II. ТЭЖЭЭВЭР АМЬТАН



III. ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР НОХОЙ, МУУР

# Оршил

Монгол улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбар юм. Хөдөө аж ахуйн салбарыг мал аж ахуй, газар тариалан гэсэн хоёр томоохон салбарт хуваадаг. Мал аж ахуйн салбарын үндсэн үзүүлэлтийн гол эх үүсвэр нь жил бүрийн мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн болон бусад тооллого, судалгаа байдаг. Газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлт нь газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тариалсан талбай, хураасан ургацын мэдээ болдог. Чингэлтэй дүүрэг нь малгүй дүүрэг тул зөвхөн ашиг шимээ өгдөг тэжээвэр амьтдыг тооллого бүртгэлд хамруулж байна.

Ойлголт тодорхойлолт:

Тариалсан талбай гэж хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Тариалангийн талбайн хэмжээг метр (м2)-аар тодорхойлж 4-99999 м2-ийн хооронд утга авна.

Нийт хураасан ургац нь тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлогдоно.

# Хөдөө аж ахуйн салбар

## Тариалсан талбай, хураасан ургац 2023 он

**2023 он**

| Хүнсний ногоо | Төмс | Жимс, жимсгэний мод |
|---|---|---|
| Тариалсан талбай 0.1 га | Тариалсан талбай 0.0466 га | Нийт мод бутны тоо 2 212 ш |
| Хураасан ургац 2.6 тн | Хураасан ургац 1.6 тн | Хураасан ургац 2 587 кг |

## Тэжээвэр амьтад 2023 он




## Гэрийн тэжээвэр нохой, муур 2021-2023 он



## ГАЗАР ТАРИАЛАН:



Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2023 онд нийт 40 өрхийн тариалсан талбай, хураалтын мэдээг хороодоос авч нэгтгэсэн. Тариалан эрхэлдэг өрхийн тоо 2022 онд 62 байсан бөгөөд 2023 онд өмнөх оноос 22 буюу 35.5%-иар буурсан байна. Мөн 0.0466 га талбайд төмс, 0.1319 га талбайд хүнсний ногоо тариалсан бөгөөд 1.56 тн төмс, 2.6 тн хүнсний ногоо хураан авсан байна. Жимс, жимсгэний жилийн мэдээнд нийт 16 хороодын 103 өрх хамрагдаж 2212 ширхэг жимсний мод, бут тариалсан байна.

Хүснэгт 1. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ХУРААСАН УРГАЦ, хороодоор, 2023 он

| Бүтээгдэхүүний нэр | 2022 он | | 2023 он | |
|---|---|---|---|---|
| | Тариалсан талбай /м2/ | Хураасан ургац, цэвэр жингээр /кг/ | Тариалсан талбай /м2/ | Хураасан ургац, цэвэр жингээр /кг/ |
| **Төмс** | 1056 | 1629 | 466 | 1560 |
| **Хүнсний ногоо** | 1644 | 2553 | 1320 | 2579 |
| Байцаа | 103 | 200 | 104 | 250 |
| Лууван | 189 | 312 | 77 | 404 |
| Шар манжин | 95 | 218 | 49 | 80 |
| Хүрэн манжин | 98 | 194 | 120 | 150 |
| Сонгино | 274 | 270 | 150 | 180 |
| Сармис | 17 | 60 | 52 | 51 |
| Өргөст хэмх | 384 | 451 | 209 | 663 |
| Өргөст хэмх (давжаа) | 30 | 20 | 31 | 26 |
| Улаан лооль | 177 | 160 | 143 | 263 |
| Тарвас | - | - | 18 | 5 |
| Амтат гуа | 3 | 12 | - | - |
| Хулуу | 13 | 51 | 15 | 133 |
| Чинжүү | 25 | 91 | 46 | 70 |
| Амтлагч ногоо | - | - | 3 | 1 |
| Цэцэгт байцаа | 50 | 126 | 12 | 53 |
| Брокколи | 49 | 45 | 14 | 50 |
| Салатны навч | 47 | 114 | 45 | 115 |
| Бууцай | 68 | 116 | 51 | 56 |
| Юуцай | 22 | 113 | 31 | 6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хаш | - | - | 2 | 2 |
| бусад | - | - | 148 | 21 |
| Цэцэг, гоёл чимэглэлийн таримал | 13 | 5 | 49 | - |

Чингэлтэй дүүргийн 2023 оны нийт ургац хураалтын 37.7%-г төмс, 16.0%-г өргөст хэмх, 9.8%-г лууван, 6.0% -г байцаа, 6.4%-г улаан лооль, 4.3%-г сонгино, үлдсэн 19.8%-г бусад хүнсний ногоо эзэлж байна.

Зураг 1. УРГАЦ ХУРААЛТ, хүнсний ногооны зарим төрлөөр 2023 он




## ТЭЖЭЭВЭР АМЬТАД:



2023 оны жилийн эцсийн тооллогоор 15 хорооны 37 өрхийн 672 тэжээвэр амьтад тоологдсон нь өнгөрсөн оны мөн үеэс 156 (30.2%)-иар өссөн байна. Тооллогоор 361 тахиа, 23 галуу, 19 нугас, 251 тагтаа, 8 цацагт хяруул, 10 туулай тоологдсон байна.

Зураг 2. ТЭЖЭЭВЭР АМЬТАД, төрлөөр 2023 он




Зураг 3. ТЭЖЭЭВЭР АМЬТАД, хороогоор




Тооллогын дүнгээр хамгийн их тэжээвэр амьтантай 7 болон 18 дугаар хороод байна.

Хүснэгт 2. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО 2017-2023 он

| Он | Бүгд | Гахай | Туулай | Илжиг | Шувуу |
|---|---|---|---|---|---|
| 2017 | 578 | 6 | 19 | 2 | 551 |
| 2018 | 519 | - | 32 | - | 487 |
| 2019 | 375 | - | 31 | - | 344 |
| 2020 | 298 | - | 9 | - | 289 |
| 2021 | 729 | - | 65 | - | 664 |
| 2022 | 516 | - | 56 | - | 460 |
| 2023 | 672 | - | 10 | - | 662 |
| Өсөлт, бууралт 2023/2022 | 30.2% | - | -82.1% | - | 43.9% |

2023 оны тэжээвэр амьтадын 662 (98.5%) нь шувуу, 10 (1.5%) нь туулай тоологдсон нь 2022 онтой харьцуулбал шувуу (43.9%)-иар өссөн бол туулай (82.1%)-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. Тэжээвэр амьтдын тоо, хороогоор 2023 он

| № | Хороод | Шувуу | | | | | | Туулай | Нийт тэжээвэр амьтан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тахиа | Тагтаа | Галуу | Бөднө | Нугас | Цацагт хяруул | | |
| 1 | 7-р хороо | 97 | - | 12 | - | 6 | - | - | **115** |
| 2 | 9-р хороо | 2 | - | - | - | - | - | - | **2** |
| 3 | 10-р хороо | 6 | 6 | - | - | - | - | - | **12** |
| 4 | 11-р хороо | 26 | 30 | - | | - | - | 8 | **64** |
| 5 | 12-р хороо | - | 12 | - | - | - | - | - | **12** |
| 6 | 13-р хороо | 4 | - | 2 | - | - | - | - | **6** |
| 7 | 14-р хороо | 35 | - | - | - | - | 4 | - | **39** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 16-р хороо | - | 30 | - | - | 9 | - | - | 39 |
| 9 | 17-р хороо | 78 | - | - | - | 4 | 4 | - | 86 |
| 10 | 18-р хороо | 8 | 141 | 4 | - | - | - | 2 | 155 |
| 11 | 19-р хороо | 23 | - | - | - | - | - | - | 23 |
| 12 | 21-р хороо | - | 7 | - | - | - | - | - | 7 |
| 13 | 22-р хороо | 30 | 25 | 5 | - | - | - | - | 60 |
| 14 | 23-р хороо | 9 | - | - | - | - | - | - | 9 |
| 15 | 24-р хороо | 43 | - | - | - | - | - | - | 43 |
| Нийт | | 361 | 251 | 23 | - | 19 | 8 | 10 | 672 |

## ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР НОХОЙ, МУУР:



Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 222 дугаар тогтоолын 2 дахь хэсэг, 2015 оны 134 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 870 дугаар захирамжийн дагуу мал тооллоготой хамтран гэрийн тэжээвэр нохой, муурны шинэчилсэн бүртгэл хийгддэг бөгөөд 2023 онд 6240 нохой, 280 муур бүртгэгдсэн ба өнгөрсөн оноос нохой 602 (8.8%)-иар, муур 34 (10.8 %)-иар буурсан байна.

Хүснэгт 4.  БҮРТГГЭГДСЭН МУУР НОХОЙНЫ ТОО, хороодоор /2021-2023 он/

| Хороо | | Нохой | | | Муур | | | Өөрчлөлт тоогоор | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Нохой | Муур |
| | | 2021 | 2022 | 2023 | 2021 | 2022 | 2023 | 2022-2023 | 2022-2023 |
| Орон сууц | 1 дүгээр хороо | 13 | 13 | 24 | 3 | 3 | 10 | 11 | 7 |
| | 2 дугаар хороо | 16 | 15 | 22 | 6 | 5 | 8 | 7 | 3 |
| | 3 дугаар хороо | 33 | 30 | 24 | 16 | 19 | 8 | -6 | -11 |
| | 4 дүгээр хороо | 43 | 46 | 37 | 10 | 10 | 11 | -9 | 1 |
| | 5 дугаар хороо | 22 | 26 | 26 | 5 | 6 | 3 | 0 | -3 |
| | 6 дугаар хороо | 37 | 34 | 34 | 6 | 16 | 16 | 0 | 0 |
| | Орон сууцны дүн | **164** | **164** | **167** | **46** | **59** | **56** | **3** | **-3** |
| Гэр хороолол | 7 дугаар хороо | 855 | 486 | 483 | 21 | 8 | 3 | -3 | -5 |
| | 8 дугаар хороо | 207 | 123 | 168 | 0 | 0 | 4 | 45 | 4 |
| | 9 дүгээр хороо | 303 | 267 | 277 | 7 | 10 | 17 | 10 | 7 |
| | 10 дугаар хороо | 406 | 435 | 352 | 9 | 5 | 13 | -83 | 8 |
| | 11 дүгээр хороо | 287 | 284 | 298 | 7 | 7 | 8 | 14 | 1 |
| | 12 дугаар хороо | 780 | 349 | 214 | 72 | 63 | 4 | -135 | -59 |
| | 13 дугаар хороо | 517 | 527 | 481 | 10 | 10 | 5 | -46 | -5 |
| | 14 дүгээр хороо | 382 | 360 | 334 | 8 | 18 | 13 | -26 | -5 |
| | 15 дугаар хороо | 485 | 489 | 449 | 8 | 20 | 18 | -40 | -2 |
| | 16 дугаар хороо | 716 | 580 | 342 | 13 | 8 | 17 | -238 | 9 |
| | 17 дугаар хороо | 1069 | 726 | 642 | 47 | 37 | 31 | -84 | -6 |
| | 18 дүгээр хороо | 478 | 420 | 427 | 5 | 4 | 26 | 7 | 22 |
| | 19 дүгээр хороо | 712 | 579 | 520 | 20 | 17 | 13 | -59 | -4 |
| | 20 дугаар хороо | - | 349 | 289 | - | 9 | 0 | -60 | -9 |
| | 21 дүгээр хороо | - | 318 | 290 | - | 9 | 8 | -28 | -1 |
| | 22 дугаар хороо | - | 0 | 169 | - | 0 | 11 | 169 | 11 |
| | 23 дугаар хороо | - | 285 | 179 | - | 18 | 27 | -106 | 9 |
| | 24 дүгээр хороо | - | 101 | 159 | - | 12 | 6 | 58 | -6 |
| | Гэр хороололын | **7197** | **6678** | **6073** | **227** | **255** | **224** | -605 | -31 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | 7361 | 6842 | 6240 | 273 | 314 | 280 | -602 | -34 |

Зураг 4. БҮРТГЭГДСЭН НОХОЙ, МУУРНЫ ТОО, 2016-2023 он




Зураг 5. БҮРТГЭГДСЭН НОХОЙ, МУУРНЫ ТОО, хороодоор, 2023 он




Бүртгэгдсэн нохой, муурны тоог хороодоор авч үзвэл 17-р хороонд хамгийн их буюу 642 нохой, 31 муур тоологдсон байна.

## Дүгнэлт

Чингэлтэй дүүрэг нь жилийн эцсийн тэжээвэр амьтдын тооллогын дүнгээр 37 өрхийн 361 тахиа, 23 галуу, 19 нугас, 251 тагтаа, 8 цацагт хяруул, 10 туулай нийт 672 тэжээвэр амьтан тоологдож, өнгөрсөн оноос 30.2%-иар өссөн байна.Тус дүүрэг нь мал аж ахуй эрхлэхийг хориглосон хотын төвийн бүс учраас сүүлийн жилүүдэд малыг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авч ажилласан.

Мөн газар тариалан эрхэлдэг өрхийн тоо жил бүр буурсаар байгаа нь дахин төлөвлөлт явагдаж газар чөлөөлж байгаатай холбоотой гэж харагдаж байна.


WWW.1212.MN
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН
Статистик
Мэдээ, мэдээлэл
Номын сан
Мэдлэгээ шалгах тоглоом
Валютын ханш
1212
©2017
аппликейшнаас
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай
Data lab
тооллого судалгааны микро мэдээллийн сан
Social network
www.facebook.com/StatisticMongolia/
www.facebook.com/chingelteistatistic
www.twitter.com/statistic_mn
Лавлах утас
70113013
70110767
70130767
11-310767
1900-1212
Цахим шуудан
chingeltei@nso.mn
information@nso.mn